



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/160

Арвайхээр

Архи, согтууруулах ундаа худалдан
борлуулах, түүгээр үйлчлэхийг
түр зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "л", 29.2, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 2021 оны ээлжит цэрэг татлагатай холбогдуулан 2021 оны 09 дүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд Арвайхээр сумын нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журмыг хамгаалах тасгийн дарга (Х.Батпүрэв)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ГАНБАТ